МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail:undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2014 . 06 . 12 № 1/966.

танай ____________-ны №____________-т

АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС (ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2014 оны А/63 дугаар тушаал, “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хууль”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах чиглэл хүргүүлж байна. Үүнд:

1. БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчид (хуучнаар)-ийн 1989 оны 198, 199 дүгээр зарлигийн дагуу 1990 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 1990 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд БНМАУ-ын (хуучнаар) “Тэтгэврийн хууль”-ийн 8, 9, 10, 10[1] дүгээр зүйл, “Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн хууль”-ийн 7, 7[1] дүгээр зүйлд заасан хугацаанд ажилласан боловч мөн зүйлд дурдсан наснаас өмнө тэтгэвэрт гарсан тэтгэвэр авагчдыг мөн хуулийн тухайн зүйлд заасан нас хүртэл хугацаагаар “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хууль”-ийн дагуу нөхөн тооцох;

Аймаг (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын хэлтэс нь дээрх тэтгэвэр авагчдын судалгааг нарийвчлан гаргаж, хариуцсан тэтгэврийн байцаагч нар тэтгэвэр авагчдын өмнөөс тэтгэврийн хувийн хэргийг үндэслэн өргөдлийн мэдүүлгийг бичиж, мэдээлэлд /refund/ бүртгэх ба баталгаажилтын хуудсыг тэтгэврийн хувийн хэрэгт байгаа хөдөлмөрийн дэвтэрт наах ажлыг зохион байгуулах;

2. Хөнгөлөлттэй нөхцөлөөр 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон иргэд, 1990-2000 онуудад тасарсан ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ хүндэтгэн үзэх болон аргагүй шалтгааны улмаас төлж, бүртгэлд хамрагдаагүй иргэд болон БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчид (хуучнаар)-ийн 1989 оны 198, 199 дүгээр зарлигийн дагуу тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийг “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хууль”-ийн дагуу 2014 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл бүртгэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс тэтгэврийн нэмэгдлийг тооцож олгохоор төлөвлөх;

3. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулахаар 2013 оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд бүртгүүлж, тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлж, баталгаажилтын хуудсаа авсан иргэдийн тэтгэврийн нэмэгдлийг олгох ажлыг хүсэлт гаргасан өдрөөс, хэрэв тэтгэвэр авагч нөхөн төлөх шимтгэлээ төлөөгүй бол төлөгдсөн сараас эхлэн тооцож олгох;

4. Хөнгөлөлттэй нөхцөлөөр 1991-1994 онуудад тэтгэвэр тогтоолгосон иргэдийн нөхөн тооцуулсан жилийн баталгаажилтийн хуудсыг тэтгэврийн хувийн хэрэгт байгаа хөдөлмөрийн дэвтэр (шинээр, нийгмийн даатгалын дэвтэр нээхгүй)-т наах ажлыг

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/63 дугаар тушаалын хуулбар, БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчид (хуучнаар)-ийн 1989 оны 198, 199 дүгээр зарлигийн хуулбар, БНМАУ-ын (хуучнаар) "Тэтгэврийн хууль", "Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн хууль"-ийн холбогдох хэсгийн хуулбарыг тус тус хавсаргав.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГА Ц.УРТНАСАН

# МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 06 өдөр Дугаар А/63 Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам"-ын 2.1 дэх хэсэгт дараах агуулга бүхий 2.1.7 дахь заалт нэмсүгэй:

"2.1.7.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 198, 199 дүгээр зарлигын дагуу тэтгэврийн насанд хүрээгүй байхдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд,

2. Энэ журмын 2.1.4 дэх заалтад "2.1.6" гэсний дараа "2.1.7" гэж нэмсүгэй.

3.Нийгмийн даатгалын байгууллага нь ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулах хүсэлт гаргасан иргэнийг 2014 оны 6 дугаар сарын 01-нээс 2014 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд бүртгэн, нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлүүлж, баталгаажилтийн хуудсыг 2014 оны 10 дугаар сарын 01-ний дотор олгохоор зохион байгуулж, 2015 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн тэтгэврийн нэмэгдлийг тооцож олгосугай.

САЙД С.ЭРДЭНЭ

Даваасамбуугийн
ДЭМБЭРЭЛ — Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн төв зөвлөлийн мужаан.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга — Ж. БАТМӨНХ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга — Ц. ГОТОВ

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ

1989 оны 12 дугаар сарын 23-ны өдөр — № 198 — Улаанбаатар хот

### БНМАУ-ЫН ТЭТГЭВРИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Тэтгэврийн хуулийн 10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«10 дугаар зүйл. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл өсгөж хүмүүжүүлсэн эмэгтэйчүүд 15-аас доошгүй жил ажилласан бол 50 нас хүрээд өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.»

2. БНМАУ-ын Тэтгэврийн хуульд доор дурдсан агуулгатай $10^2$ дугаар зүйл нэмсүгэй:

«$10^2$ дугаар зүйл. Энэ хуулийн 8, 9, 10, $10^1$ дүгээр зүйлд заасанаас доошгүй жил ажилласан боловч тэтгэврийн насанд 3 хүртэл жил дутуу байгаа ажилчин, албан хаагч гурав хүртэл насны хүүхдээ болон байнга асрах өөр хүнгүй ач, зээгээ асран хүмүүжүүлэхийг хүсвэл өндөр насны тэтгэвэр авах эрхтэй».



3. Энэ зарлигийг 1990 оны 7 дугаар сарын 1-нээс дагаж мөрдөхөөр тогтоосугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга — Ж. БАТМӨНХ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга — Ц. ГОТОВ

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ

1989 оны 12 дугаар сарын 23-ны өдөр — № 199 — Улаанбаатар хот

### БНМАУ-ЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭГДЛИЙН ГИШҮҮДИЙН ТЭТГЭВРИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн хуульд доор дурдсан агуулгатай $7^1$ дүгээр зүйл нэмсүгэй:

«$7^1$ дүгээр зүйл. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл өсгөж хүмүүжүүлсэн эмэгтэйчүүд 15-аас доошгүй жил ажилласан бол 50 нас хүрээд өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.

Энэ хуулийн 7 дугаар зүйл, энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасанаас доошгүй жил ажилласан боловч тэтгэврийн насанд 3 хүртэл жил дутуу байгаа хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн 3 хүртэл насны хүүхдээ болон байнга асрах өөр хүнгүй ач, зээгээ асран хүмүүжүүлэхийг хүсвэл өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.»

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулж БНМАУ-ын Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн «б» заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ зарлигийг 1990 оны 7 дугаар сарын 1-нээс даг[illegible]
мөрдөхөөр тогтоосугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн дарга Ж. БАТМӨН[illegible]

БНМАУ-ын Ардын Их Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн
бичгийн дарга Ц. ГОТОВ



## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ

[illegible] оны 12 дугаар [illegible] 23-ны өдөр | № 201 | Улаанбаатар хот

4 дүгээр зүйл. Улсын тэтгэвэр авах эрх бүхий хүмүүс тэтгэвэр авах тухай хүсэлтээ дуртай цагтаа гаргаж болно.

5 дугаар зүйл. Улсын тэтгэврийг аймаг, хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын тэтгэвэр тогтоох орон тооны бус байнгын комисс тогтооно. Уг комиссын шийдвэрийн талаар аймаг, хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргаанд, гүйцэтгэх захиргааны шийдвэрийн талаар Улсын нийгэм хангамжийн ерөнхий газарт гомдол гаргаж болно.*

6 дугаар зүйл. Улсын тэтгэвэрт зарцуулагдах хөрөнгийг БНМАУ-ын төсөв, түүний дотор нийгмийн даатгалын хөрөнгөнөөс гаргана.

7 дугаар зүйл. Улсын тэтгэврээс ашиг орлогын татвар үл хураана.

## Хоёр. ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР

8 дугаар зүйл. Өндөр насны тэтгэврийг нийтдээ 25-аас доошгүй жил ажилласан 60 нас хүрсэн эрэгтэйчүүд, нийтдээ 20-иос доошгүй жил ажилласан 55 нас хүрсэн эмэгтэйчүүд авах эрхтэй.

9 дүгээр зүйл. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хөдөлмөр, цалин хөлсний улсын хороо, Монголын үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөлөөс баталсан хөдөлмөрийн хүнд, хортой, халуун нөхцөл, газар доорхи ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалтад дурдсан хүмүүст өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтооно:

а) улсад нийтдээ 20-иос доошгүй жил ажиллаж, түүний 10-аас доошгүйг хөдөлмөрийн хортой, халуун нөхцөл, газар доорхи ажилд ажилласан 50 нас хүрсэн эрэгтэйчүүд, 15-аас доошгүй жил ажиллаж, түүний 7 жил 6 сараас доошгүйг мөн нөхцөлд ажилласан 45 нас хүрсэн эмэгтэйчүүд;

б) улсад нийтдээ 25-аас доошгүй жил ажиллаж, түүний 12 жил 6 сараас доошгүйг хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласан 55 нас хүрсэн эрэгтэйчүүд, 20-иос доошгүй жил ажиллаж, түүний 10-аас доошгүйг мөн нөхцөлд ажилласан 50 нас хүрсэн эмэгтэйчүүд;

Ажилчин, албан хаагчдын нас, ажилласан хугацаа нь энэ зүйлд тохирвол өмнө буюу дараа нь хөдөлмөрийн ямар нөхцөлд ажилласныг үл харгалзан тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтооно.**

* БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1979 оны 7-р сарын 2-ны өдрийн 189-р зарлигийн найруулга
** БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1972 оны 5-р сарын 9-ний өдрийн 93-р зарлигийн найруулга.



10 дугаар зүйл. 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж 6 нас хүртэл бойжуулан хүмүүжүүлсэн эмэгтэйчүүд 15 жилээс доошгүй ажилласан бол 50 нас хүрээд өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.

10[1] дүгээр зүйл. Харaагүй болсноос тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа бөгөөд улсад 15-аас доошгүй жил ажилласан 50 нас хүрсэн эрэгтэйчүүд, 10-аас доошгүй жил ажилласан 40 нас хүрсэн эмэгтэйчүүд өөрсдөө хүсвэл тахир дутуугийн тэтгэврийн оронд өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.*

11 дүгээр зүйл. Өндөр насны тэтгэвэр авахад нас хүрсэн боловч ажилласан хугацаа хүрээгүй ажилчин, албан хаагчид улсад нийтдээ 5-аас доошгүй жил ажилласны дотор тэтгэвэрт гарахын өмнө 3 жил тасралтгүй ажилласан бол тэдэнд тэтгэврийг нийт ажилласан хугацаанд хувь тэнцүүлэн тогтоох бөгөөд тэтгэврийн доод хэмжээ нь 50 төгрөг байна.** Харин эдгээр хүмүүс ажиллаж байвал уг тэтгэврийг олгохгүй.***

12 дугаар зүйл. Өндөр насны тэтгэврийг дор дурдсан хэмжээгээр тогтооно:

| Сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр) | Хэвийн нөхцөлд | | Хүнд, хортой, халуун нөхцөлд | | Газар доорхи нөхцөлд | |
|---|---|---|---|---|---|---|
| | цалингаас бодох хувь | тэтгэврийн доод хэмжээ | цалингаас бодох хувь | тэтгэврийн доод хэмжээ | цалингаас бодох хувь | тэтгэврийн доод хэмжээ |
| 200 хүртэл | 90 | 150 | 100 | — | — | — |
| 201—300 | 75 | 180 | 80 | 200 | 100 | — |
| 301—400 | 60 | 225 | 70 | 240 | 85 | 300 |
| 401—600 | 50 | 240 | 55 | 280 | 75 | 340 |
| 601—800 | 40 | 300 | 45 | 330 | 65 | 450 |
| 801—1000 | 35 | 320 | 40 | 360 | 60 | 520 |
| 1001-ээс дээш | 30 | 350 | 35 | 400 | 55 | 600 |

Өндөр насны тэтгэврийн доод хэмжээг сар бүр 150 төгрөг, дээд хэмжээг 800 төгрөгөөр тогтооно.****

* БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 7-р сарын 20-ны өдрийн 127-р зарлигаар нэмсэн.
** БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 12-р сарын 25-ны өдрийн 300-р зарлигийн найруулга.
*** БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1979 оны 7-р сарын 2-ны өдрийн 189-р зарлигаар нэмсэн.
**** БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 7-р сарын 20-ны өдрийн 127-р зарлигийн найруулга.

улсын тэтгэвэр тогтоох орон тооны бус байнгын комисс тогтоонo. Уг комиссын шийдвэрийн талаар аймаг /хот/-ийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанд, гүйцэтгэх захиргааны шийдвэрийн талаар БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хороонд гомдол гаргаж болно.

5 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэвэрт зарцуулах хөрөнгийг БНМАУ-ын улсын төсвөөс санхүүжүүлнэ.

6 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврээс ашиг орлогын татвар хураахгүй.

## ХОЁР. ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР

7 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн өндөр насны тэтгэврийг хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолын байгууллагад нийтдээ 25-аас доошгүй жил ажилласан 60 нас хүрсэн эрэгтэй гишүүд, нийтдээ 20-иос доошгүй жил ажилласан 55 нас хүрсэн эмэгтэй гишүүд авах эрхтэй.

8 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн өндөр насны тэтгэврийг тэдний сарын дундаж хөлсний 100 хүртэл төгрөгөөс 90 хувь, үлдэх хэсгээс 80 хувиар бодож тогтооно. Өндөр насны тэтгэврийн доод хэмжээ сард 60 төгрөг, дээд хэмжээ сард 300 төгрөг байна.

9 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн өндөр насны тэтгэвэр авахдаа дор дурдсан нэмэгдлийг тэтгэврийн дээд хэмжээнд багтаан олгоно:

а/ хөдөө аж ахуйн нэгдэл,хоршоолын байгууллагад 15 жил тасралтгүй ажилласан буюу тухайн хүний тэтгэвэр тогтоолгоход ажилласан байвал зохих нийт хугацаанаас 10-аас доошгүй жил илүү ажилласан бол тэтгэврийн 10 хувь;

б/ дөрөв, түүнээс дээш хүүхэд төрүүлж, 6 нас хүртэл хүмүүжүүлсэн эхчүүдэд тэтгэврийн 10 хувь.

10 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийг анх үүсгэн байгуулахад гишүүнээр элсэж, тэтгэвэр тогтоолгох нас хүртлээ нэгдэлд тасралтгүй ажилласан хүмүүст ажилласан хугацааг хар-



галзахгүйгээр энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан хэмжээгээр өндөр насны тэтгэвэр тогтоож олгоно. Хэрэв тэдний тасралтгүй ажилласан хугацаа нь 15 жилээс доошгүй байвал тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлж олгоно.

11 дүгээр зүйл. Өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн боловч ажилласан хугацаа хүрээгүй хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд нэгдэл хоршоолын байгууллагад нийтдээ тавaас доошгүй жил ажилласны дотор тэтгэвэрт гарахын өмнө хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолын байгууллагад гурван жил тасралтгүй ажилласан бол тэдэнд тэтгэврийг нийт ажилласан хугацаанд хувь тэнцүүлэн тогтоох бөгөөд тэтгэврийн доод хэмжээ нь 80 төгрөг байна.

12 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн өндөр насны тэтгэврийг хөдөлмөрлөх чадвартай эсэхийг үл харгалзан бүх насаар нь олгоно.

## ГУРАВ. ТАХИР ДУТУУГИЙН ТЭТГЭВЭР

13 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд тахир дутуугийн I, II группэд орвол тэтгэвэр авах эрхтэй.

14 дүгээр зүйл. Үйлдвэрлэлтэй холбогдсон осол гэмтэл буюу мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн улмаас тахир дутуу болсон хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдэд тэдний ажилласан хугацааг үл харгалзан тэтгэврийг дор дурдсан хэмжээгээр тогтооно:

| Групп | Сарын дундаж хөлсний хэд хүртэлх төгрөгөөс | Хөдөн хувиар | Үлдэх хэсгээс хэдэн хувиар |
|---|---|---|---|
| I | 100 | 100 | 15 |
| II | 100 | 90 | 15 |

15 дугаар зүйл. Ердийн өвчлөлийн улмаас тахир дутуу болсон хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүд дор дурдсан нас, нийт ажилласан хугацааг хангасан бол тэдэнд тэтгэвэр олгоно:

...дийн дарга

Ц. ГОТОВ